



«Мөнгө угаах» гэсэн ойлголт өнгөрсөн зууны 20-иод онд Чикагогийн гэмт бүлэглэлийн толгойлогч Аль Капонегийн үед анх бий болжээ. Тэр үед Америкт «хуурай» хууль буюу архины худалдааг хязгаарласан хууль үйлчилж байх үед Аль Капоне архи, хар тамхи, худалдаа, рэкетийн хууль бус үйлдлээсээ олсон мөнгөө өөрийн эзэмшлийн хувцас угаалгын газруудаас олсон ашиг мэтээр тайлан тооцоо гаргадаг байв. Үүнийг нь «L'express» сонины сэтгүүлчид анх олж мэдээд тэднийг «Хувцас биш мөнгө угааж байна» гэж бичсэнээр «мөнгө угаах» гэсэн нэр томъёо анх гарч ирсэн гэдэг. 1974 онд АНУ-ын Ерөнхийлөгч Ричард Никсоныг огцруулж байсан «Watergate»-ийн дуулианы үеэр энэ нэр дахин гарч ирснээр

дэлхий нийтэд танил болж, олон улсын гэмт хэргийн болон санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх болжээ.

Тэр үед Ричард Никсоныг дэмжих «Ерөнхийлөгчийг дахин сонгох хороо»-гоор дамжуулан нууц данс ашиглан хууль бус мөнгийг Мексик рүү гуйвуулж байсан нь тогтоогджээ. Үүнээс хойш дэлхийн улс орнуудад мөнгө угаах нэр томъёог хэрэглэж эхэлсэн байна.



Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх гэмт хэрэг нь эдийн засаг, нийгмийн ихээхэн сөрөг үр дагавартай. Тухайлбал, их хэмжээний мөнгө гэнэт орж ирээд гэнэт гарах нь санхүүгийн системийн тогтвортой байдлыг алдагдуулах, цаашлаад хямралд ч хүргэж болзошгүй юм. Түүнчлэн, олон улсад дотоодын банк, санхүүгийн байгууллагын нэр хүнд алдагдах, тэдгээртэй харилцахаас татгалзах зэрэг хохирлыг дагуулдаг байна. Хууль бус мөнгө дотоодынх бол тус мөнгө нь хээл хахууль, авилгыг гааруулах, шударга өрсөлдөөнийг үгүй хийх, шударгаар бизнес эрхлэгчдийг зах зээлээс шахан гаргаж, монополь байдал бий болгох зэрэг олон сөрөг үр дагавартай.



АНУ-ын тинк-танк судалгааны төвөөс 2003-2013 онуудын хооронд мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх өндөр эрсдэлтэй орнуудын дундаж угаагдсан буюу «бохир мөнгө»-ний хэмжээ 80 их наяд доллар гарсан гэж мэдээлсэн.

Илт хууль бусаар олсон хөрөнгө, мөнгө, орлого гэдгийг мэдсээр байж түүнийг авсан, эзэмшсэн, ашигласныг, эсхүл түүний хууль бус эх үүсвэрийг нь нуун далдлах, гэмт хэрэг үйлдэхэд оролцсон аливаа этгээдэд хуулийн хариуцлагаас зайлсхийхэд туслах зорилгоор өөрчилсөн, шилжүүлснийг, эсхүл түүний бодит шинж чанар, эх үүсвэр, байршил, захиран зарцуулах арга, эзэмшигч, эд хөрөнгийн эрхийг нуун далдалсныг мөнгө угаах гэж Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй



тэмцэх тухай хуулиар тогтоосон. Өөрөөр хэлбэл гэмт хэрэг үйлдэх замаар олсон мөнгө, хөрөнгөө цэвэршүүлж, хууль ёсны болгохыг хэлж байгаа юм. Анх мөнгө угаах арга нь энгийн байсан бөгөөд гэмт хэрэгтэн Аль Капонегийн хууль бусаар олсон мөнгөө хууль ёсны болгох үүднээс Чикаго хотын хими цэвэрлэгээ, угаалгын газруудыг ашигладаг байсан учир ийм төрлийн хууль бус ажиллагааг «Мөнгө угаах» буюу «Money Laundering» гэж нэрлэх болсон гэдэг.

Мөнгө угаах гэмт хэрэг үйлдэж буй түгээмэл аргууд:

- Хар зах зээл дээрх Колумбын песогийн арилжаа (Black market colombian peso exchange);
- Хадгаламжинд байршуулах;
- Хууль ёсны бизнест хөрөнгө оруулах;
- Гадаадын банкүүд;
- Итгэлцэл дээр суурилсан банкны үйл ажиллагаа.





БАЙРШУУЛАХ ҮЕ ШАТ

Их хэмжээний бэлэн мөнгийг өөртөө хадгалах нь хүндрэлтэй тул Мэргэжлийн үйлчилгээ эрхлэгчдийн эсвэл хууль хяналтын байгууллагын анхаарлыг таталгүйгээр санхүүгийн системд нэвтрүүлж, хууль бусаар олсон мөнгөний анхны эс үүсвэрээс «салах»-ыг зорино.

Арга техникүүд:

- Их дүнтэй мөнгийг Мэргэжлийн үйлчилгээ эрхлэгчид Санхүү, мэдээллийн албанд цааш мэдээлэх хэмжээнд хүргэхээс сэргийлж бага дүнтэй хэсгүүдэд хувааж санхүүгийн системд нэвтрүүлэх;
- Мэдээлэх хэмжээнд хүргэхээс сэргийлж мөнгийг бага багаар гадаад валютад хөрвүүлэх;
- Бэлэн мөнгийг мэдээлэх хэмжээнд хүргэлгүй бага хэмжээгээр өөр улс руу биетээр зөөвөрлөх;
- Хууль бусаар олсон мөнгөөр зээлийн төлбөрөө төлөх;
- Хууль ёсны орлоготой «бохир» мөнгийг хольж санхүүгийн системд нэвтрүүлэх;
- Хуурамчаар нэхэмжлэл үйлдэх г.м.



НУУН ДАЛДЛАХ ҮЕ ШАТ

Хууль бусаар олсон хөрөнгийг жинхэнэ эх үүсвэрээс нь холдуулах, төөрөгдүүлэх зорилгоор эргэлзээ төрүүлж, хөрөнгийг олон төрлийн ээдрээтэй гүйлгээ хийж санхүүгийн системийн эргэн тойронд эргэлдүүлнэ.

Арга техникүүд:

- Бэлэн мөнгийг санхүүгийн хэрэглүүрт шилжүүлэх
- Өөр өөр дансуудаар дамжуулан олон удаагийн олон төрлийн гүйлгээг хийж төөрөгдөл үүсгэх
- Хөрөнгийг оншор болон оффшор дансууд руу шилжүүлэх
- «Бохир» мөнгөөр бараа, бүтээгдэхүүн худалдан авч түүнийг тухайн улс оронд, эсвэл гадаад улсад эргүүлж борлуулах
- «Бохир» мөнгийг цахим мөнгөнд шилжүүлж гуйвуулга хийх г.м



БУЦААН ТӨВЛӨРҮҮЛЭХ ҮЕ ШАТ

Гэмт хэрэгтнүүд хууль бусаар олсон хөрөнгийг санхүүгийн системд нэвтрүүлээд нуун далдлах үе шатын дараа буцаан төвлөрүүлэх үе шат руу шилжүүлэх ба энэ үед нэмэлт гүйлгээнүүдийг хийх замаар хөрөнгийн хууль ёсны мэт харагдуулахыг зорьдог.

Арга техникүүд:

- Үл хөдлөх хөрөнгө худалдан авах
- Бизнес худалдан авах
- Үнэтэй машин, үнэт эдлэл зэрэг тансаг хэрэглээний бараа, бүтээгдэхүүн худалдан авах
- Биетээр оршдоггүй, хуурамч байгууллагын» ажилтнуудын» цалинг авах г.м.



Мөнгө угаах нь эдийн засаг, нийгмийн ихээхэн сөрөг үр дагавартай. Хууль бус мөнгө гаднаас орж ирсэн бол зорилгодоо хүрээд гэнэт орж ирсэн шигээ гэнэт буцаад гарна. Их хэмжээний мөнгө гэнэт орж ирээд гэнэт гарах нь санхүүгийн системийн тогтвортой байдлыг алдагдуулаад зогсохгүй хямралд ч хүргэж болох юм. Үүний зэрэгцээ олон улсын тавцанд дотоодын банк, санхүүгийн байгууллагуудын нэр хүнд унах, банк, санхүүгийн байгууллагаар дамжин хийгдэж байгаа гадаад гүйлгээг саатуулан шалгах, тэдгээртэй харилцахаас татгалзах хүртэлх арга хэмжээг гадны орнууд авч болох юм.

Хууль бус мөнгө дотоодынх бол энэ нь хээл хахууль, авлигыг гааруулах, шударга өрсөлдөөнийг үгүй хийх, шударгаар бизнес эрхлэгчдийг зах зээлээс шахаж монополь байдал бий болгох зэрэг олон сөрөг үр дагавартай. Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоо сул хөгжсөн орнуудыг мөнгө угаагчид ашиглах эрсдэл өндөр байдаг.

МӨНГӨ УГААХ ГЭМТ ХЭРГИЙН НИЙГМИЙН ХОР АЮУЛ

- Үлэмж хэмжээний эд хөрөнгө эдийн засгийн үндэслэлгүй улс дамнан шилжих нь зарим улс орон, тэр ч бүү хэл бүс нутгийн санхүү, эдийн засаг, нийгэм, улс төрийн нөхцөл байдалд асар их хор уршигтай.
- Хууль ёсны эргэлтэнд орж угаагдсан мөнгө зохион байгуулалттай гэмт хэрэг, авлига, терроризмын санхүүгийн эх үүсвэрийг бүрдүүлэх үржил шимтэй хөрс нь болдог.
- Шударга, чөлөөт өрсөлдөөний зарчим алдагддаг.
- Санхүүгийн байгууллагын хүчин чадлыг доройтуулдаг
- Улсын төсөвт орох орлого буурч, татвараа шударгаар төлөгч иргэдийг хохироодог.



Монгол Улсад гарч буй мөнгө угаах гэмт хэргийн талаар зарим гүйцэтгэх ажилтан, мөрдөн байцаагч нартай ярилцлага хийх аргаар судлахад, энэ төрлийн гэмт хэрэг нь дараах аргаар үйлдэгддэг гэж үзэж байна:



- Гэмт хэргийн замаар олсон орлогоо гадаадын банканд дахь дансанд шилжүүлэх, ингэхдээ гэмт хэрэгтнүүд өөрсдийн гэр бүл, эцэг, эх, ах дүү, хамаатан садан, ойр дотныхоо хүний нэр дээрх дансанд гүйвуулах
- Гадаадын иргэд «бохир» мөнгөө Монголд оруулж ирэхдээ уул уурхайн салбарт хөрөнгө оруулалт хийх халхавчаар оруулж ирэн, буцааж гаргах
- Үнэт металл худалдан авч, хууль бусаар Монгол Улсын хилээр гарган, олсон хууль бус орлогоо буцаан оруулж, эргэлтэнд оруулах
- Төрийн зарим албан хаагчид албан тушаалын байдлаа урвуулан ашиглан, хээл хахуулийн журмаар олсон хууль бус орлогоо гадаад, дотоодын банкны тогтолцоогоор дамжуулан хууль ёсны мэт болгохыг оролдох
- Төрийн өмчит компанийн удирдлагад ажиллаж байсан зарим хүмүүс албан тушаалын байдлаа урвуулан ашиглах, хуурамч гэрээ байгуулан, хөрөнгө мөнгийг гадаадын хэд хэдэн улс руу гарган, буцаан оруулж ирэх гэх мэт.

- Террорист байгууллага, террорист хүн, эсхүл террорист үйл ажиллагаанд зарцуулагдахыг мэдсээр байж шууд, эсхүл шууд бусаар эд хөрөнгө хуримтлуулсан, шилжүүлсэн, зарцуулсныг «терроризмыг санхүүжүүлэх» гэж Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулиар тогтоосон.
- Өөрөөр хэлбэл террорист үйл ажиллагааг санхүүжүүлэх, үүнтэй холбоотой, магадлалтай байх гүйлгээ хийхийг терроризмыг санхүүжүүлэх гэж нэрлэдэг.
- Террорист үйл ажиллагаа нь хүний амь насыг санаатай бүрэлгэх, үй олноор хөнөөх, хүн барьцаалах, гэмтээх, түүх, соёлын үнэт өвийг санаатай хорлон сүйтгэх замаар төр засаг болоод олон улсын байгууллагыг аливаа нэг үйлдэл хийлгэхгүй байх тактик юм.



Бэлэг тэмдэг



Улс төр



Өш хонзон



Шашин шүтлэг

ТЕРРОРИЗМЫГ ЯМАР ЭХ СУРВАЛЖААС САНХҮҮЖҮҮЛДЭГ ВЭ?

Хууль бус санхүүжилтийн эх үүсвэр

- Айлган сүрдүүлэх замаар мөнгө дээрэмдэх
- Хүн барьцаалж мөнгө шаардах
- Хүний болон эд эрхтний наймаа
- Хар тамхины худалдаа
- Залилан, хулгай, дээрэм
- Цахим гэмт хэрэг үйлдэж мөнгө нэхэх



Хууль ёсны санхүүжилтийн эх үүсвэр

- - Төр засгаас өгсөн хандив тусламж
- - Бизнес болон хувиараа хөдөлмөр эрхэлж олсон хууль ёсны орлого
- - Ар гэр, найз нөхдийн өгсөн мөнгө
- - Хандив, тусламжийн хөрөнгө



	Мөнгө угаах	Терроризмыг санхүүжүүлэх
Сэдэл	Ашиг хонжоо	Үзэл суртал
Эх үүсвэр	Голдуу хууль бус үйл ажиллагаанаас олсон орлого байна	Хууль ёсны болон хууль бус үйл ажиллагаанаас олсон орлого аль аль нь байх боломжтой
Хэмжээ	Их дүнтэй	Ихэвчлэн бага дүнтэй
Арга хэлбэр	Нуун далдлах арга техникүүдийг ашиглаж хөрөнгийг жинхэнэ эх үүсвэрээс нь холдуулах бүх арга хэмжээг авах	Голдуу албан бус шилжүүлэг, гадаад валют арилжааны төвүүдийг ашиглаж эцсийн хэрэглэгч рүү мөнгийг чиглүүлэх
Эцсийн зорилго	«Бохир» мөнгийг угааж хууль ёсны санхүүгийн системд нийлүүлэх	Террорист үйл ажиллагааг дэмжих
Хөрөнгийн урсгал	Дугуй буюу хөрөнгө анхны эзэндээ эргэж очно	Шугаман буюу хөрөнгө анхны эзэн рүүгээ эргэж ирэхгүй



Монгол Улс 2003 онд «Терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх олон улсын конвенц»-д нэгдэн орж, 2004 онд мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагаатай тэмцэх, тэдгээрээс урьдчилан сэргийлэх олон улсын бодлогыг тодорхойлдог Олон улсын санхүүгийн арга хэмжээ авах бүлэг (Financial Action Task Force буюу ФАТФ)-ийн салбар байгууллага болох Ази, Номхон далайн бүс нутгийн мөнгө угаахтай тэмцэх байгууллага (APG)-д элсэн орсноор мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх олон улсын стандартыг мөрдөж ажиллах үүрэг хүлээх болсон.

Монгол Улсад анх 2006 оны 7 дугаар сард «Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль» батлагдсан бөгөөд энэхүү хууль нь 2013 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн шинэчилсэн

найруулгаар хэрэгжиж байна. Тус хуулийн 16 дугаар зүйлийн дагуу мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хууль тогтоомжийг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий Санхүүгийн мэдээллийн алба (СМА) Монголбанкны дэргэд байгуулагдан үйл ажиллагаа явуулж байна.

2- Монгол улсын Эрүүгийн хуулийн тусгай ангийн 1661 дугаар зүйлийг 2014 оны 1 дүгээр сарын 16-ны өдөр дараах байдлаар өөрчлөн найруулсан:

1661 дугаар зүйл. Мөнгө угаах

1661.1. Гэмт хэргийн улмаас олсон хөрөнгө, мөнгө, орлого гэдгийг мэдсээр байж түүнийг авсан, эзэмшсэн, ашигласан, эсхүл түүний хууль бус эх үүсвэрийг нь нуух, далдлах, гэмт хэрэг үйлдэхэд оролцсон аливаа этгээдэд хуулийн хариуцлагаас зайлсхийхэд туслах

зорилгоор өөрчилсөн, шилжүүлсэн, эсхүл түүний бодит шинж чанар, эх үүсвэр, байршил,

захиран зарцуулах арга, эзэмшигч, эсхүл эд хөрөнгийн эрхийг нуусан, далдалсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавиас нэг зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг сараас зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах, эсхүл таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

1661.2. Энэ гэмт хэргийн улмаас онц их хэмжээний хохирол учирсан, эсхүл албан тушаалтан албаны чиг үүрэг, бүрэн эрх, нөлөөг урвуулан ашиглаж үйлдсэн, эсхүл зохион байгуулалттай бүлэг, гэмт бүлэглэл үйлдсэн бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг гурван зуугаас таван зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

1661.3. Энэ гэмт хэргийг хуулийн этгээд үйлдсэн бол тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрхийг хасаж, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг гурван зуугаас таван зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох ял шийтгэнэ гэж тусгасан байна.

3- Монголбанкны ерөнхийлөгчийн 2015.12.25-ны өдрийн А-207 дугаар тушаалаар батлагдсан «Банкны

мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагаанд газар дээрх хяналт, шалгалт хийх журам», «Банкны мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагаанд зайнаас хяналт, шалгалт хийх журам», Монголбанкны ерөнхийлөгч, Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2011.03.18-ны өдрийн 156/45 дугаар тушаалаар батлагдсан «Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр банкнаас бусад мэдээлэх үүрэгтэй этгээдэд хяналт шалгалт хийх журам», 2016.06.30-ны өдрийн А162/195 дугаар тушаалаар батлагдсан «Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журам» зэрэг эрх зүйн актаар Монгол улсад мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг зохион байгуулах харилцааг зохицуулдаг.

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулиар хүлээсэн үүргээ биелүүлж байгаад хяналт тавих байгууллага

№	Санхүүгийн зохицуулах хороо, Санхүүгийн мэдээллийн албатай хамтран	Монголбанк
1	Банк бус санхүүгийн байгууллага (ББСБ)	
2	Даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогч	
3	Хөрөнгө оруулалтын сан (ХОС)	
4	Үнэт цаасны зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллага	БАНК
5	Хадгаламж, зээлийн хоршоо (ХЗХ)	
6	Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллага	
7	Нотариатч	



НҮБ-ын конвенц, тогтоол:

- Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлтийн эсрэг нэгдсэн үндэстний байгууллагын конвенц- 1988 он;
- «Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх болон Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхтэй тэмцэх Олон улсын стандарт-ФАФТ-ын зөвлөмж 2012 он;
- Терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх конвенц-1999 он;
- Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх Палермогийн конвенц- 2000 он;
- НҮБ-ын Аюулгүйн зөвлөлийн 1267, 1373 дугаар тогтоол. «Террорист этгээдийн жагсаалтад оруулах, жагсаалтад орсон этгээдийн хөрөнгийн хөдөлгөөнийг зогсоох, хянах» журам.

Эдгээр тогтоол нь террорист байгууллага, этгээдийн хөрөнгийг хураах, тэдгээрийн нэр дээр хийгдэх гүйлгээг түдгэлзүүлэх гэх мэт арга хэмжээ авахыг НҮБ-ын гишүүн орнуудад үүрэг болгосон. Манай улс эдгээр конвенц, тогтоолд нэгдэн орсон бөгөөд олон улсын өмнө мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үүрэг хүлээж байгаа юм.

ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭ:

Харилцагчид



- Бэлэн мөнгө ихээр эргэлддэг бизнес
- Хяналт зохицуулалтгүй хандивийн байгууллага
- Улс төрд нөлөө бүхий этгээд
- Үнэт эдлэлийн наймаачид
- Гадаад улсын иргэд
- Сэжиг бүхий бизнесийн түншүүдийн

Бүтээгдэхүүн
үйлчилгээ

- - Итгэлцлийн үйлчилгээ
- - Мөнгөн гуйвуулгын үйлчилгээ
- - Гадаад валют арилжаа

Газар зүйн
байршил

- - ФАТФ-ын саарал, хар жагсаалтанд багтсан
- - НҮБ-ын Аюулгүйн зөвлөлөөс гаргасан жагсаалтанд багтсан
- - МУТСТ тогтолцоо бүрдээгүй
- - Авилгын болон гэмт хэргийн түвшин өндөр улс орнууд
- - Эмбарго, санкцитай улсууд

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО /СЗХ/ ГЭЖ ЮУ ВЭ?

Санхүүгийн зохицуулах хороо нь Санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах, санхүүгийн үйлчилгээг зохицуулах, холбогдох хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих, хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалах чиг үүрэг бүхий төрийн байгууллага юм.

Үйл ажиллагааны хамрах хүрээнд дараах мэдээлэх үүрэгтэй этгээдүүдийг зохицуулахаар хуульчлагдсан. Үүнд:

банк бус санхүүгийн байгууллага;

- даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогч;
- үнэт цаасны зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллага;
- хадгаламж зээлийн хоршоо;
- харилцагчийн нэрийн өмнөөс үл хөдлөх хөрөнгө худалдан авах эсхүл худалдах аливаа ажиллагаа явуулдаг бол үл хөдлөх эд хөрөнгийн зуучлалын байгууллага.

Санхүүгийн зохицуулах хороо нь:

- Мэдээлэх үүрэгтэй этгээдэд газар дээрх шалгалт хийх, зайнаас хяналт тавих, шалгалтын удирдамж, журам, заавар, зөвлөмж гаргах;
- Хуулиар хүлээсэн үүргийн хэрэгжилтийг хангуулах,

хяналт тавих, шалгалт хийх зорилгоор баримт, тайлан, мэдээлэл, тайлбар гаргуулан авах;

- Нөлөө бүхий хувьцаа эзэмшигч, хувь нийлүүлсэн хөрөнгийн гарал үүсэл, гүйцэтгэх удирдлага, ажилтанд тавигдах шаардлагыг тодорхойлох;
- Санхүүгийн нэгдлийн оролцогч нь өөр улсад бүртгэгдсэн, эсхүл байршдаг бол холбогдох хяналт тавих эрх бүхий байгууллага нь тухайн улсын хяналт тавих эрх бүхий байгууллагатай гэрээ, харилцан ойлголцлын санамж бичиг байгуулан мэдээлэл солилцох, хамтарсан шалгалт хийх хэлбэрээр хамтран ажиллах;
- Хуулиар хүлээсэн үүргийн хэрэгжилтийг хангуулах, хяналт шалгалтын үйл ажиллагааны нэгдмэл байдлыг хангах зорилгоор холбогдох хяналт тавих эрх бүхий байгууллага хоорондоо болон Санхүүгийн мэдээллийн албатай мэдээлэл солилцох, хамтран ажиллах;
- МУТСТ хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан авч байгаа арга хэмжээ болон хариуцлагын талаарх статистик мэдээг нийтэд түгээх;

САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЛИЙН АЛБА /СМА/ ГЭЖ ЮУ ВЭ?

Энэ хуулийн 16 дугаар зүйлийн дагуу мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хууль тогтоомжийг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий Санхүүгийн мэдээллийн алба (СМА) Монголбанкны дэргэд байгуулагдан үйл ажиллагаа явуулж байна.

Санхүүгийн мэдээллийн алба нь:

1. Мэдээллийг хүлээн авах, мэдээллийн сан бүрдүүлэх, дүн шинжилгээ хийх;
2. Төрийн эрх бүхий байгууллагад шилжүүлэн шалгуулах, эргэж мэдээлэх;
3. Сэжигтэй гүйлгээг илрүүлэх, хянах аргачлал боловсруулж мэдээлэх үүрэгтэй этгээдэд мэдээлэх, хэрэгжилтийг зохион байгуулах;
4. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль тогтоомжийн биелэлтийг хянан шалгаж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах талаар арга хэмжээ авч ажиллах;
5. Гадаад, дотоодын болон олон улсын байгууллагуудтай хууль тогтоомжийн хүрээнд хамтран ажиллах чиг үүрэгтэй байгууллага юм.

Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хууль нь банк, банк бус санхүүгийн байгууллага, даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогч, үнэт цаасны зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллага, хадгаламж зээлийн хоршоо, үл хөдлөх хөрөнгө зуучлалын байгууллага нотариатч гээд маш өргөн хүрээг хамарсан хууль юм. Дээрх хуулийн этгээдүүд нь хуулийн дагуу мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой гэж үзсэн болон 20 сая төгрөг түүнтэй тэнцэх хэмжээний гадаад валют/ буюу түүнээс дээш үнийн дүнтэй бэлэн мөнгө, гадаад төлбөр тооцооны гүйлгээний талаар СМА-д мэдэгдэх үүрэгтэй.

Монгол Улс мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх сайн тогтолцоо, сайтар бэхэжсэн Санхүүгийн мэдээллийн албатай байснаар гэмт этгээдүүд манай санхүүгийн байгууллагуудын нэр хүндийг олон улсын тавцанд унагахаас урьдчилан сэргийлж, шударгаар бизнес эрхлэгчдийг хамгаалж чадах болно.